



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

᠒᠐᠒5 оны ᠐᠖ сарын ᠒᠖ өдөр

Дугаар ᠐3/34

Баян-Өндөр сум

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр
хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймагт төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Түншлэлийн төслийн жагсаалтыг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, гэрээ байгуулсан түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг орон нутгийн төсвийн гүйцэтгэлтэй хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025
оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Ээлжит бус
V хуралдааны 09 дугаар тогтоолын хавсралт



**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

№	Төслийн нэр	Төсөл хэрэгжих салбар
1.	Хойд бүсийн тээвэр логистикийн төв	Тээвэр логистик
2.	Цахилгаан дулааны дэд төв, станц	Эрчим хүч, дулаан хангамж
3.	Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл	Эрчим хүч, дулаан хангамж
4.	Хотын доторх гэрэлтүүлгийн засвар арчилгаа	Хот тохижилтын үйлчилгээ
5.	Ахмад настны асаргаа, сувилгааны төв	Хүн ам, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ
6.	Спортын цогцолбор төв	Биеийн тамир спортын үйлчилгээ
7.	Бурхан багшийн сэрэг дүр аялал жуулчлалын цогцолбор	Соёл, амралтын үйлчилгээ
8.	Эрдэнэт цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, шинэчлэлт	Соёл, спортын үйлчилгээ
9.	Улсын чанартай А1001, А1002 авто замаас урд чиглэлд Эрдэнэт хотыг тойрон өнгөрөх шинэ авто зам барих төсөл	Авто зам
10.	Олон Улсын уран зургийн галерей, Музей	Соёлын үйлчилгээ
11.	Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол	Боловсролын үйлчилгээ
12.	Баян-Өндөр уул орчмын аялал жуулчлалын цогцолбор	Соёл, амралтын үйлчилгээ
13.	Аюултай хог хаягдал болон дахивар боловсруулах үйлдвэр	Хог хаягдлын менежмент
14.	“Монгол ёс заншлын өргөө” цогцолбор	Соёл, амралтын үйлчилгээ
15.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангасан хүнсний худалдааны цогцолбор	Хүнсний хангамж, аюулгүй байдлын хангахад чиглэсэн үйл ажиллагаа